



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2003 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 932

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2003 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г үндэслэн ТУШААХ НЬ:

1. Аумахан овогтой Булбулгүлийг АНУ-ын Өмнөд Каролайнагийн Их сургуулийн докторантурт халдвар судлалын чиглэлээр, Бархүү овогтой Бат-Эрдэнийг Англи улсын Манчестерийн Их сургуулийн докторантурт дотор эрхтэн шилжүүлэн суулгах дархлал судлалын чиглэлээр, Нацаг овогтой Бурмааг ХБНГУ-ын Шпайерийн Төрийн захиргааны дээд сургуулийн докторантурт төрийн аудитын чиглэлээр 2003-2004 оны хичээлийн жилээс 3 жилийн хугацаагаар тус тус суралцуулсугай.
2. Далай овогтой Эрдэнэ-Отгоныг 2003-2004 оны хичээлийн жилээс Голландын Маастрихтын Удирдлагын сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар суралцуулсугай.
3. ОХУ-ын Москвагийн Олон улсын Харилцааны Дээд сургуульд япон судлалын чиглэлээр суралцаж буй Занабазар овогтой Чинбазарын сүүлийн нэг жилийн сургалтын төлбөрийг, Япон улсын Бүдогийн Их сургуулийн дасгалжуулагчийн ангид суралцаж буй Балжинням овогтой Батболдын сүүлийн 2 жилийн сургалтын зардлыг, АНУ-ын Форт Коллинз хот дахь Колорадогийн Улсын Их сургуульд компьютерийн чиглэлээр суралцаж буй Махвал овогтой Чандманий сүүлийн 2 жилийн сургалтын төлбөрийг зээлээр олгосугай.
4. ХБНГУ-ын Берлин хотын Гумболдтын Их сургуулийн докторантурт элэгний удамшилт өвчин судлалын чиглэлээр суралцаж буй Лхагвасүрэн овогтой Содномцогтын суралцах хугацааг нэг жилээр сунгасугай.

02638

5. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



А.ЦАНЖИД